

2025 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалт болон Худалдаа, хөгжлийн банкны сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийх журмын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**


1. Банкны өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүн, үйлчилгээг Банкны холбогдох этгээдүүдийн ажилтнуудад үзүүлэхтэй холбоотой “Хамтран ажиллах гэрээ” буюу Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-36 дугаар тушаалын хавсралт Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг “Худалдаа, хөгжлийн банкны холбогдох этгээдүүд”-тэй байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Банкийг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын дагуу хийсэн гэрээ хэлцлийн мэдээллийг улирал бүр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, батламжлуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА